

**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД ОРУУЛАХ ӨӨРЧЛӨЛТИЙН ТӨСЛИЙГ ХОЁР
ДАХЬ ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ БЭЛТГЭСЭН БОЛОН МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД
ОРУУЛСАН ӨӨРЧЛӨЛТИЙГ ДАГАЖ МӨРДӨХӨД ШИЛЖИХ ЖУРМЫН ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН АНХНЫ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ ЯВУУЛСАН ТАЛААРХ
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2023 оны 05 дугаар
сарын 17-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн нэг дэх хэлэлцүүлэг болон Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2023 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар явуулж, Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт, Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт тус тус бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

“Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр, гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх тухай” Улсын Их Хурлын 2023 оны 37 дугаар тогтоол, “Улсын Их Хурлын гишүүд тойрогт ажиллах тухай” Улсын Их Хурлын даргын 2023 оны 85 дугаар захирамжийн дагуу Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн хэлэлцүүлгийн үе шат хооронд төслийг иргэдэд танилцуулах, мэдээллээр хангах, санал бодлыг сонсох зорилгоор Улсын Их Хурлын гишүүд 2023 оны 05 дугаар сарын 06-ны өдрөөс 16-ны өдрүүдэд тойрогтоо ажилласан болно.

Хууль зүйн байнгын хороо 2023 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсэгт заасныг баримтлан хэлэлцсэн болно.

Түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан бөгөөд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу зүйл бүрээр хэлэлцлээ.

Төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар өөрийн бүрэн эрхийг өргөтгөх, хязгаарлах асуудлаар Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл санаачилж болохгүй гэж заасан бөгөөд Засгийн газраас санаачилсан төслийн Улсын Их Хуралтай холбоотой заалтыг гишүүд санал гаргаж өөрчлөх эрх байгаа эсэх талаар асуулт асууж, хариулт авсан.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл болон Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гаргаагүй болно.


Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг нэгдсэн хуралдааны хоёр дахь хэлэлцүүлэгт оруулахыг хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй буюу 80 хувийн саналаар дэмжиж, Төрийн байгуулалтын байнгын хороонд санал, дүгнэлтээ хүргүүлэхээр тогтлоо.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн болон Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Б.ЭНХБАЯР